

ХҮҮХДИЙН НИЙГЭМШИЛД ГАР УТАСНЫ ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА

(7 дугаар ангийн сурагчдын гар утас ашиглаж буй жишээн дээр)

Хуан Шио Ин, ӨМБИС

Abstract

Childhood plays an important role in human social process. In this period, they learn the new ideas and new behaviors from his surroundings and change their original habit patterns, and ready to become a member of society. With the development of science and technology, mankind has entered the information society. Mobile phone acting as one of the most important representatives of the information society, bringing convenience to social life. At the same time, its shortcomings have gradually emerged and contained negative information has brought serious problems on the growth and socialization of children. Therefore, to provide children with a clean and pollution-free social environment are becoming the most urgent problem for the school, parents and society.

In this study, to investigate the positive and negative effects of mobile phones on children's socialization processes, we selected the seventh grade students as subjects and used a questionnaire survey method, investigated the positive and negative effects of socialization on children. Research indicates that students have a consciousness of using the phone to find learning materials; Students spend a lot of leisure time on their mobile phones and proved that the impact of information tools is growing; Mobile phones have a significant impact on children's socialization, however, greater attention should be given to other factors that influence the socialization of children.

Түлхвэн үг

Хүүхэд, нийгэмшил, гар утас, дүн шинжилгээ, сөрөг нөлөөлөл

Удиртгал

Хүн төрөлхтний гар утастай танилцсан түүх тун саяхных. Тодруулбал, 40 гаруйхан жилийн түүхтэй. Гар утсанд “ухаалаг” гэх тодотгол бий болж, хүүхэд гэлтгүй хүн бүрийн хэрэглээ болсон нь бүр ч саяхны түүх. Хүний нийгэмшилд хүүхэд нас туйлын чухал үе шат юм. Хүүхэд өдөр бүр орчин тойрноосоо шинэ мэдлэг мэдээлэл авч, шинэ зүйлийг сурч, өөрийн гэсэн шинэ ертөнцийг бүтээснээр нийгмийн нэг гишүүн болохоор бэлтгэгдэж байдаг билээ.

Шинжлэх ухаан, технологийн хөгжлийг дагалдан хүн төрөлхтөн мэдээллийн нийгэмд амьдарч байна. Мэдээллийн нийгмийн хамгийн чухал төлөөлөгчийн нэг болох гар утас хүмүүсийн амьдралд хэрэгцээт мэдээллийг цаг алдалгүй түгээж буй давуу талтай ч түүний сул тал хүүхэд багачуудын өсөж бойжих ба нийгэмшихэд сөргөөр нөлөөлж буйд нийгэм, сургууль, эцэг эхийн зүгээс хамтын ажиллагааг шаардагтай байгааг илэрхийлж байна.

Нөгөө талаар гар утас хоргүй төдийгүй ашигтай гэдгийг баталсан судалгаанууд байдаг. Гэвч гар утасны сөрөг нөлөөлөл эерэг нөлөөллөөсөө их байгаа нь тодорхой билээ. Энэ талаар олон судалгааны ажил хийгдэж, эрдэмтдийн нийтлэл, өгүүлэл олноор нийтлэгдсэн ч өнөөг хүртэл бүрэн шийдвэрлэгдээгүй байна. Гар утас нь хорт туяа, долгионы цацрагийг дамжуулж, ялгаруулж байдаг

бөгөөд тэдгээр нь хүний биед шингэдэг.

Энэхүү гар утаснаас ялгарч буй долгионтой холбоотой үүсдэг асуудал нь тархины хавдар үүсгэдэг хэмээн судлаачид үздэг. 2008 онд Швед улсад хийгдсэн нэгэн судалгаагаар гар утсыг хэрэглэдэг хүүхдүүд төв мэдрэлийн тогтолцооны глиаль эсийн хавдар болох глиамаар өвчлөх магадлал өндөр байна хэмээн дүгнэсэн бол 2000 онд хийгдсэн нэгэн судалгааны үр дүнд хүүхдүүдийг онцгой тохиолдолд л утас ашиглахыг зөвлөсөн байна. Шведийн Оребро дахь анагаах ухааны сургуулийн эмнэлгээс хийгдсэн судалгааны судлаачид гар утас хэрэглэдэг хүүхэд болон өсвөр насныхан тархины хавдраар өвчлөх магадлалтай гэсэн дүгнэлтэд хүрчээ. Энэ мэтчилэн гар утасны сөрөг нөлөөллийн судалгааны талаар цөөнгүй мэдээллийг дурдаж болохоор байна.

Америкийн судлаачийн судалгааг үндэслэвэл (国际新闻界, 20006, х.4) гар утас хэмээх мэдээллийн хэрэгсэл нь хүмүүст өөрийн оршиж буй орчин тойрны талаар мэдээлэл авахад хөтөч болоод зогсохгүй бид гар утаснаас авсан мэдээлэлгүйгээр өдөр тутмын амьдралаа төсөөлөх боломжгүй болжээ. Хүүхэд багачуудад авч хэлбэл, нийгмийн тухай мэдлэг туршлага харьцангуйгаар насанд хүрэгсдийг бодвол бага тул нөлөө нь ч харьцангуй их байдаг. Ийм учраас мэдээллийн хэрэгслийн хүүхдийн нийгэмшихэд нөлөөлөх

ээрэг, сөрөг нөлөөллийн асуудалд дүн шинжилгээ хийх нь тулгамдсан асуудал болно.

Ухаалаг гар утсыг сургуулийн орчинд хязгаарласан олон улсын туршлага олон бий. Тухайлбал, Японы Айчи мужийн Кария хотод бүх бага болон дунд сургуулийн сурагчид оройн 21.00 цагаас хойш ухаалаг гар утас ашиглахыг хоригложээ. Энэ нь ч үр дүнгээ өгч, сурагчдын нийгмийн идэвх сайжирч, сурлагын амжилтад нь огцом өсөлт гарчээ. Монголын цөөнгүй дунд сургуулиуд ухаалаг хэмээн нэрлэгдэх гар утас ашиглахыг хориглоод байгаа нь сурагчид хичээлдээ идэвх, дур сонирхолтой байхын үндэс болж байна. Гэвч хамгийн чухал нь, багш нар сурагчдад аль болох интернет орчноос даалгавар, бие даалт өгөхгүй байхыг сануулжээ.

Энэхүү судалгааны өгүүллийн хүрээнд 7 дугаар ангийн сурагчдын нас сэтгэхүйн онцлогтой уялдуулан асуулгыг зохиож, гар утас хүүхэд багачуудын нийгэмшилд хэрхэн нөлөөлж буй нөлөөллийн судалгаагаар дамжуулан дүн

шинжилгээ хийх зорилго тавилаа.

Дээрх судалгааны зорилгыг хэрэгжүүлэх үүднээс дараах зорилтуудыг дэвшүүлсэн болно.

- 7 дугаар ангийн хүүхэд гар утсаар ямар мэдээлэл авдаг, тэрхүү мэдээлэл нь тухайн сурагчийн хичээл сурлагад нь дэмжлэг болж чаддаг эсэхийг ойлгож, дүн шинжилгээ хийх.
- 7 дугаар ангийн хүүхэд өдөр бүр хэдэн цагаар гар утас хэрэглэдэг, өдөрт ямар хугацаанд гар утаснаас хамааралтай байгаа асуудлыг тодруулах
- Гар утаснаас хүүхэд тухайн нийгмийн тухай ойлголт, мэдлэгийг хэр авдаг төдийгүй сурагчдын нийгэмшилд эерэг, сөрөг ямар нөлөө үзүүлдэг асуудалд дүн шинжилгээ хийх

Судлагдахуун:

Улаанбаатар хотын 5-р сургуулийн 7-р ангийн сурагчид.

Нэг. Судалгааны онол ба практикийн асуудал

Бидний судалгаагаар сурагчдын нийгэмшил хэмээх ойлголт нь хувь хүн нийгмийн туршлага, нийгмийн харилцаа, холбоо зэргийг эзэмшихтэй холбоо бүхий чадвар, үйл явц юм. (Ичинхорлоо, 2006, х.17) Орчин үеийн мэдээллийн хэрэгсэл олон төрөл хэдий ч хүн бүр өдөр тутмын хэрэглээ болгосон гар утас нь 7 дугаар ангийн сурагчдын нийгэмшихэд ямар нөлөөлөл үзүүлж байгаа асуудлыг судлах нь чухал хэмээн үзсэн болно.

Тус судалгааг бид асуулгын аргаар явуулсан бөгөөд 7 дугаар ангийн сурагчдад урьдчилан бэлтгэсэн асуулгын хуудас тараан өгч, асуулгын хариултыг нэгтгэн дүн шинжилгээ хийв. Асуулгын хуудсыг нийт 70 ширхгийг сурагчдад тараан өгснөөс хүчинтэй хуудас 69 ширхэг байв. Үүнээс гадна 5 сурагчтай гар утасны хэрэглээний тухай асуудлаар ганцаарчилсан ярилцлага хийсэн болно.

Хүснэгт 1

7 дугаар ангийн сурагчдын ерөнхий байдал

Асуулга 1	Эрэгтэй			Эмэгтэй			Найд		
	A	B	C	A	B	C	A	B	C
	21	15		23	10		44	25	
Асуулга 2	A	B	C	A	B	C	A	B	C
	5	22	8	4	22	8	9	44	16
Асуулга 3	A	B	D	A	B	D	A	B	D
	15	11	8	14	8	13	29	19	21
Асуулга 4	A	B		A	B		A	B	
	19	16		22	12		41	28	
Асуулга 5	A	B		A	B		A	B	
	30	5		26	8		56	13	
Асуулга 6	A	B		A	B		A	B	
	20	18		16	15		36	33	

Асуулгын хуудсыг үндэслэвэл, нийт 69 сурагч, эрэгтэй 36, эмэгтэй 33 сурагч. Ихэнх нь 12 настай. Сурагчдын хариултаас харвал хүйсийн ялгаанаас үүссэн асуудал илэрсэнгүй. Үүнээс үзвэл сурагчид гар утас хэрэглэхэд хүйсийн ялгаатай байдал нөлөөгүй гэдэг нь харагдсан болно.

2. Гар утас нь 7 дугаар ангийн сурагчдын хичээл, сурлагад ямар эерэг нөлөөлөл үзүүлдэг талаар дүн шинжилгээ хийх асуулга.

Асуулга 1. “Гар утас таны хичээлд тусламж болж чаддаг уу?” гэсэн асуултад: тусламж болж чаддаг гэж асуултад оролцсон 69 сурагчийн 44 сурагч хариулсан бөгөөд нийт сурагчдын 64%, тусламж болж чаддаггүй гэж 25 сурагч хариулсан бөгөөд нийт сурагчийн 36%-ийг эзэлж байна. (Зураг 1) Үүнээс үзэхэд сурагч гар утсыг хичээл болон гэрийн даалгавар хийхдээ ашиглаж байгаа нь нөгөө талаар сурагчдад нэмэлт мэдээлэл авах эх үүсвэр болж байгааг илэрхийлсэн үзүүлэлт хэмээн үзэж болохоор байна.

Диаграмм 1


Гар утас таны хичээлд тусламж болж чаддаг уу?



Асуулга 3. “Гар утас хэрэглэж байх үедээ юуг голлон ашигладаг вэ?” гэсэн асуултад сурагчид “Холбоо барих”, “Сүлжээнд нэвтрэх”, “нэмэлт мэдээлэл, материал хайх” зэрэг гурван сонголт тус бүр 29, 19, 21 харьцаатай байж, 30% эзэлж байна.

Диаграмм 2

Гар утас хэрэглэж байх үедээ юуг голлон ашигладаг вэ?



Гэвч Асуулт 2-оос “тоглоом тоглох” гэсэн хариултыг сонгосон сурагч байхгүй байсан нь бодит байдалтай нийцэхгүй төдийгүй судалгааны дүгнэлт хийхэд бэрхшээлтэй байдлыг бий болгосон гэдгийг хэлэх нь зүйтэй болов уу.


3. Хүүхэд багачууд өдөр бүр хэдэн цаг гар утас хэрэглэдэг асуудлыг судлах

Асуулт 5. “Та өдөрт хэдэн цагаар гар утас хэрэглэдэг вэ?” гэсэн асуултад 1-2 цаг хэрэглэдэг гэсэн хариултыг дийлэнх сурагчид буюу нийт 56 сурагч, 3-4 цаг хэрэглэдэг хэмээн 13 сурагч, сонирхолтой нь 4-өөс дээш хэрэглэдэг гэсэн

хариултыг хэн ч сонгоогүй байсан болно. Тус асуулгын хариултыг дүгнэн үзвэл сурагчид ихэвчлэн гар утсанд өдөр бүр 1-2 цаг зарцуулдаг бөгөөд Асуулт 3-т хариулсан хариултаас харвал ихэвчлэн холбоо барих, цахим ертөнцөөр аялах, хичээлтэй холбоотой мэдлэг, мэдээлэл хайхад зарцуулдаг байна. (Диаграмм 3)

Диаграмм 3

Сурагчид өдөрт хэдэн цаг гар утас хэрэглэдэг вэ?




Харин “тоглоом тоглох зорилгоор гар утас ашигладаг уу?” гэсэн асуултад эерэг үзүүлэлт гарсан нь үнэн бодитой байдлаас зөрүүтэй дүн хэмээн дүгнэж болохоор байна. Учир нь бидний судалгааны орчны тохиромжгүй байдал, ангийн болон хичээл ордог багш тус судалгааг авахад хамт байсан зэрэг энэхүү судалгааны асуулга бодитой бус гарахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн хэмээн үзэж болно. Тус судалгааны дүн бодит байдлаас зөрүүтэй гарсан нь нийгэм дэх сурагчдын нийгэмшил хүмүүжлийн асуудалтай холбоотой төдийгүй дээрх судалгааны асуулгаар дамжуулан гар утасны сөрөг нөлөөллийн асуудлыг бүхэлд нь тодруулах боломжгүй, цаашид цогц судалгаа хийх шаардлагатай гэдгийг харуулж байна.

4. Гар утас 7 дугаар ангийн сурагчдын нийгэмшилд ямар нөлөө үзүүлж буй асуудлыг шинжлэх

Асуулт 2. “Гар утас танд нийгмийн тухай ойлголт, мэдлэгийг ямар хэмжээнд олгодог вэ?” гэсэн асуултад “Дунд зэрэг” гэсэн хариултыг сонгосон сурагч 44, “Маш их” гэсэн хариултыг 16 сурагч сонгосон байна. Энэхүү хоёр хариултаас үзвэл, сурагчид тухайн нийгмийн тухай ойлголт, мэдлэг нь гар утасны хэрэглээтэй холбоотой гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна. Дээрх асуулгаас харвал сурагчдын 87% нь гар утаснаас нийгмийн талаарх мэдлэг, мэдээллийг олж авч байгаа нь гар утаснаас хамааралтай гэдгийн илэрхийлэл болно. Гэвч гар утаснаас хамааралтай байх нь эерэг, сөрөг нөлөөтэй гэдгийг хараахан тогтоох аргагүй, зөвхөн асуулт нэгийн “хичээлд тусламж болдог” гэсэн асуулгатай уялдуулан үзвэл эерэг нөлөөлөл бага хэмээн дүгнэж байна.

Диagramм 4

Гар утас танд нийгмийн тухай ойлголт, мэдлэгийг ямар хэмжээнд олгодог вэ?



5. Ганцаарчилсан ярилцлагын аргаар авсан судалгаанд хийсэн анализ

Сурагчдаас асуулгын аргаар судалгаа авахаас гадна мөн ганцаарчилсан ярилцлагын аргаар судалгааг хийсэн болно.

Сурагчдаас “Танд гар утас байдаг уу?, Гар утас худалдан авах хүсэлтэй юу?” гэсэн 2 асуултыг асуусан бөгөөд тэд бүгд тийм гэсэн хариултыг өгсөн болно. Түүнчлэн “Та гар утасны тоглоом хэр их тоглодог вэ?” гэсэн асуултад мөн бүгд “тоглодог” гэсэн хариултыг өгсөн нь асуулгын аргаар авсан судалгааны дүнтэй зөрж байсан болно. Тиймээс магадгүй энэхүү судалгааг асуулгын аргаар бус ганцаарчилсан ярилцлагын аргаар авах нь илүү тохиромжтой байсан болов уу гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Санал, зөвлөмж

Гар утасны хэрэглээнээс үүдэн гарах эрүүл мэндийн эрсдэлийг багасгахын тулд

- Та хүүхдэдэ нарийн учрыг тайлбарлан, тэдэнд ойлгуулан, гар утасны хэрэглээг багасгах шийдвэрт хамтдаа хүрэх
- Хүүхдийг аль болох утсаар бага яриулах
- Гар утсаар ярихдаа чихэвч микрофон ашиглах
- Найзуудтайгаа холбогдохдоо утсаар ярихаас илүүтэйгээр мессеж илгээхийг зөвлөх

Дүгнэлт

- Гар утас сурагчдын сурлагад дэмжлэг болдог хэдий ч сурагчид гар утсыг хэрэглэн өөртөө хэрэгтэй материалыг олж авдаг тул гар утсыг хэрэглэх хэрэгцээ өндөр байна. Энэ нь нийгэм даяар харилцаа холбооны дэвшлийг хүртэж, түүнээс улам бүр хамааралтай болж байгаа асуудлын илэрхийлэл болно.
- Хүүхэд багачууд чөлөөт цагийнхаа ихэнх хэсгийг зарцуулж байгаа нь судалгаагаар харагдаж байна. Энэ нь сурагчид гар утас

зэрэг мэдээллийн хэрэгсэлд улам автах болж, багш, эцэг эхчүүдийн анхаарлаа хандуулах чухал асуудал мөн тул гар утасны хэрэглээг багасгаж, биеийн тамираар хичээллэх сонирхлыг төрүүлэх ажлыг санаачлан хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

- Сурагчдын нийгэмшилд гар утас харьцангуй сөрөг нөлөө үзүүлж байна хэмээн дүгнэж болохоор байна. Тиймээс цаашид сурагчдын нийгэмшилтэй холбоотой зарим асуудлыг тодруулан судлах шаардлагатай байна. Жишээлбэл, хүүхэд багачууд тоглоом тоглодог уу гэсэн асуултад багш, аав ээжийн шүүмжлэлээс зайлсхийхийн тулд судалгааг үнэн зөв бөглөхгүй байсан хандлага нь сөрөг төлөвшил тогтох магадлалтай гэдгийг илэрхийлж байна.
- Нэгэнт технологийн дэвшилтэй хөл нийлүүлэн алхаж байгаа өнөөгийн нийгэмд ухаалаг хэрэглээнээс татгалзах амаргүй. Гэсэн ч хүүхдийнхээ эрүүл мэнд, ирээдүйг аврахын тулд ямар нэгэн алхам хийхээс өөр аргагүй болоод байна. Энэ нь сургуулийн орчинд ухаалаг утсыг бүрмөсөн хориглох явдал болно.
- Тиймээс бид сургууль, цэцэрлэгийн орчинд цахим сүлжээг хаах, эцэг эхчүүд үр хүүхэд, өөрсдийнхөө эрүүл мэндэд анхаарч хэрэглээгээ хязгаарлая гэсэн саналыг дэвшүүлж байна. Энэ нь ухаалаг утсанд донтож байгаа хүүхдийн асуудлыг ч давхар шийдэх боломж, гарц юм.

Ашигласан материал

宋小卫西方学者论媒介素养教育,国际新闻界[J]. 国际新闻界, 2000:4

Ичинхорлоо, Ш. (2011). *Боловсролын социологийн удиртгал*. Улаанбаатар